

**ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧИГЛЭЛЭЭР**  
**ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**  
/2018.09.26-2018.10.25/

1. Томилогдсон, түр томилогдсон албан хаагчийн талаар:

Тайлангийн хугацаанд:

- 1.1 Ажилд томилогдсон: А.Дэлгэрсүрэнг Виз, зөвшөөрлийн газарт мэргэжилтнээр, Р.Зоригоог Албадан гаргах ажиллагааны хэлтэст мэргэжилтнээр тус тус 2 албан хаагч төрийн захиргааны албан хаагчаар томилсон байна.
- 1.2 Шинээр томилогдсон төрийн үйлчилгээний албан хаагч: П.Мөнхбаатарыг Буянт-Ухаа дахь газрын жолоочоор, Х.Мичидмааг Хангалт үйлчилгээний газарт биеийн тамирын арга зүйчээр нарын 2 албан хаагчийг шинээр томилсон.
- 1.3 Дэвшүүлэн томилсон: П.Тулгыг Дорноговь аймаг дахь газрын даргаар, Тамгын газрын дэд даргын туслах Э.Эрдэнэдавааг Хяналт шалгалтын газрын хяналтын улсын байцаагчаар, Хангалт үйлчилгээний газрын биеийн тамирын арга зүйч М.Энххүслэнг Тамгын газарт дэд даргын туслахаар тус тус 3 албан хаагчыг томиллоо.
- 1.4 Шилжүүлэн томилсон: Хойд бүс дэх газрын Дархан-Уул аймаг дахь хяналтын улсын байцаагч П.Бороог Хойд бүс дэх газарт хяналтын улсын байцаагчаар шилжүүлэн томилсон.
- 1.5 Түр орлон гүйцэтгүүлэх: Эрх зүй, гадаад харилцааны хэлтсийн мэргэжилтэн Т.Батгэрэлийг гадаад харилцааны ахлах мэргэжилтний үүргийг, хуулийн мэргэжилтэн М.Золзаяаг хуулийн ахлах мэргэжилтний үүргийг тус тус түр орлон гүйцэтгүүлж байна.

2. Чөлөөлөгдсөн, түр чөлөөлөгдсөн, халагдсан албан хаагчийн талаар:

- 2.1. Төрийн захиргааны албан хаагчид: Зүүн бүс дэх газрын хяналтын улсын байцаагч Ц.Анхбаярыг өөрийн хүсэлтээр чөлөөлсөн.
- 2.2 Түр чөлөөлөгдсөн: Буянт-Ухаа дахь газрын хяналтын улсын байцаагч С.Халиуныг урт хугацааны сургалтад хамрагдах шалтгаанаар түр чөлөөлсөн.
- 2.3 Төрийн үйлчилгээний албан хаагчид: Буянт-Ухаа дахь газрын жолооч Г.Отгонбаатарыг өөрийн хүсэлтээр, Боомт орон нутгийн хэлтсийн диспитчер Г.Батбаярыг өөрийн хүсэлтээр, Мэдээллийн технологийн хэлтсийн гэрээт ажилтан Г.Сэргэлэнбаатарыг өөрийн хүсэлтээр тус тус 3 албан хаагч чөлөөлөгдсөн.

3. Чөлөө олгосон талаар: Өмнөд бүс дэх газрын захиргааны ахлах мэргэжилтэн Э.Шинэтуяа, Санхүүгийн хэлтсийн тооцооны нягтлан бодогч Б.Хишигжаргал, төсвийн ахлах мэргэжилтэн Х.Отгонжаргал нарт хүүхэд асрах чөлөө, Буянт-Ухаа дахь газрын хяналтын улсын байцаагч Б.Нарангэрэлд эрүүл мэндийн шалтгаанаар 90 хоногийн чөлөө, Хойд бүс дэх газрын жолооч Э.Ууганбаярт эрүүл мэндийн шалтгаанаар 68 хоногийн чөлөө, Зүүн бүс дэх газрын виз зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн С.Баясгаланд эрүүл мэндийн шалтгаанаар 15 хоногийн чөлөө, Буянт-Ухаа дахь газрын хяналтын улсын байцаагч Т.Соёл-Эрдэнэд эрүүл мэндийн шалтгаанаар 60 хоногийн чөлөө тус тус 7 албан хаагч чөлөө авсан бол Баруун бүс дэх газрын Баян-Өлгий аймаг дахь хэлтсийн мэргэжилтэн С.Алтаннур хүүхэд асрах чөлөө авсан байна.

#### 4. Мөнгөн тусламж, шагнал урамшуулал олгосон талаар:

Тусламж – Буянт-Ухаа дахь газрын нярав Н.Алтанчимэг, Санхүүгийн хэлтсийн тооцооны нягтлан бодогч Б.Хишигжаргал, Санхүүгийн хэлтсийн төсвийн ахлах мэргэжилтэн Х.Отгонжаргал, Баруун бүс дэх газрын Баян-Өлгий аймаг дахь хэлтсийн мэргэжилтэн С.Алтаннур нарын гэр бүлд шинээр хүүхэд төрсний 100,000 төгрөг буюу нийт 4 албан хаагчид 400,000 мянган төгрөгний тусламж олгосон.

Урамшил олгох тухай: Эрх зүй, гадаад харилцааны хэлтсийн мэргэжилтэн Т.Батгэрэлд ахлах мэргэжилтний үүргийг хавсран гүйцэтгүүлсэний 40%, Хуулийн мэргэжилтэн М.Золзаяад ахлах мэргэжилтний үүргийг хавсран гүйцэтгүүлсний 40%, Зүүн бүс дэх газрын мэргэжилтэн Г.Хосбаатар, Х.Тайванбаатар нарт цалингийн 20% тус тус олгосон байна.

Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолоор баталсан "Төрийн үйлчилгээний албаны албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам"-ын дагуу 10 сард 73 төрийн үйлчилгээний албан хаагчид цалингийн 10%-25% -ийн ур чадварын нэмэгдэл олгосон байна.

Тайлангийн хугацаанд сахилгын шийтгэл ногдуулаагүй байна.

#### **Үндсэн үйл ажиллагааны чиглэлээр:**

Сар бүрийн хариуцсан ажлын хүрээнд албан хаагчдын цагийн тооцоо, ур чадварын нэмэгдлийг тооцож, нэгтгэн батлуулан холбогдох газар хэлтэст хүлээлгэн өгсөн.

Улс тунхагласны баяраар Хууль зүй дотоод хэргийн яамны хүндэт жуух бичгээр шагнуулахаар 7 албан хаагчийн нэрийг дэвшүүлж, материалыг бэлтгэж яаманд хүргүүлсэн.

Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргуулах сонгон шалгаруулалтад тэнцсэн Дорноговь аймаг дахь газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Тулгыг байгууллагын дэргэдэх салбар зөвлөлөөр хэлэлцүүлж салбар зөвлөлийн тогтоолоор жинхэлсэн байна.

Байгууллагын албан хаагчдыг адистатчлах шалгалтыг угтаж бүх албан хаагчдаар дэлгэрэнгүй анкет бөглүүлж хүний нөөцтэй холбоотой судалгааг шинэчилж ажиллаа.

Байгууллагын түүхэн замналын номын эх бэлтгэлд зориулж албан хаагчдын төрийн дээд одон медалийн болон хууль зүйн дотоод хэргийн яамны шагналын судалгааг шинэчилж гаргаж бэлтгэлээ.

Тус хугацаанд хүний нөөцтэй холбоотойгоор Б-28 тушаалын төсөл боловсруулж бэлтгэж гаргасан байна.

ТАЙЛАН БИЧСЭН: ХҮНИЙ НӨӨЦИЙН  
МЭРГЭЖИЛТЭН

М.ӨНӨРЦЭЦЭГ

ХЯНАСАН: ХҮНИЙ НӨӨЦИЙН  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Д.ШИНЭБАЯР